



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/1022

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг нэгдүгээр, төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын ТҮБД ангиллын 5 дугаар шатлалаар 2022 оны 1,2 дугаар сард цалинжиж байсан багш, ажилтны цалингийн доод хэмжээг энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан хэмжээнээс 5 хувиар нэмэгдүүлэн тогтоохыг холбогдох төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтийн бэлтгэл ханган, зохион байгуулалтыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (О.Хуягцогт)-т, Боловсролын ерөнхий газар /Г.Ням-очир/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ч.Энх-Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

. 142210423

Боловсрол, шинжлэх ухааны  
сайдын 2022 оны 04 дүгээр  
сарын 01 -ны өдрийн 1122 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт




Төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн  
төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТҮБД - 1	757907
ТҮБД - 2	911449
ТҮБД - 3	1005130
ТҮБД - 4	1063537
ТҮБД - 5	1126198

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2022 оны 04 дүгээр сарын 01... -ны  
едрийн А/1022 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



Төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн  
төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан хаагчдын  
албан тушаалын цалингийн хэмжээ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТҮ – 4	590937
ТҮ - 5	635776
ТҮ– 6	709759
ТҮ – 7	766481
ТҮ - 8	797676